



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/145

Хэрлэн сум

Г Зудын хариу арга хэмжээний ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. “Дэлхийн Зөн Монгол” Олон Улсын Байгууллагаас хэрэгжүүлж байгаа “Зудын хариу арга хэмжээ” төслийг удирдан зохион байгуулах аймгийн ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Ж.Энх-Амгалан Аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын дарга

Нарийн бичгийн

дарга: Г.Жаргалбат Дэлхийн зөн Монгол олон Улсын байгууллагын Бор-Өндөр 2 Орон нутгийн хөтөлбөрийн менежер

Гишүүд: Г.Пүрэвбаатар

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

Э.Хонгорзул

Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын дарга

О.Баярмагнай

Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч

Г.Гантөмөр

Хүнс Хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны дарга

Ц.Үүрцайх

Дэлхийн зөн Монгол олон Улсын байгууллагын Бор-Өндөр 2 Орон нутгийн хөтөлбөрийн менежер зохицуулагч

Б.Цэрэнчимэд

Хэнтий аймгийн Хөдөө аж ахуйн хоршоологчдын холбооны дарга

П.Мөнхбаатар

Аймгийн Улаан загалмайн хорооны ажилтан

2.

2.Ажлын хэсгийг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Ж.Энх-Амгалан)-д захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ